

"Си И Си инвестмент ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

"Си И Си инвестмент ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 11 дүгээр сарын 03-нд үүсгэн байгуулагдсан.

ТУЗ нь 2023 онд 2 удаагийн ээлжит биет хурлыг компанийн байр болох Хан-уул дүүргийн 18-р хороо, Моннис бьюлдинг 3 давхарт хийсэн болно.

ТУЗ нь нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 1 хараат бус гишүүнтэй болно.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

1. ТУЗ-ийн дарга Х.Гиймаа
2. ТУЗ-ийн гишүүн Э.Ундрах
3. ТУЗ-ийн гишүүн С.Мягмардорж
4. ТУЗ-ийн гишүүн Н.Урантуяа
5. ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ханддорж
6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Батцэцэг

№	Он сар, өдөр	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр	Ирц
1	2023.04.28	1. Компанийн 1-р улирлын үр дүнгийн тайлан 2. Компанийн 2023 оны төлөвлөгөөнд орсон өөрчлөлт, хүлээгдэж байгаа гүйцэтгэл 3. Финтек зээлийн танилцуулга, зээлийн лимит батлуулах 4. Итгэлцлийн үйлчилгээний нөхцөлийн танилцуулга, нөхцөл батлуулах 5. Голомт болон МИК-с зээлийн шугам	1. Компанийн 2, 3, 4-р улирлын төлөвлөгөөг тоон үзүүлэлтээр гаргаж шинэчлэн ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэх. 2. Итгэлцлийн үйлчилгээний журмыг боловсруулж ТУЗ-ийн гишүүдэд танилцуулах. 3. Финтек зээлийн нөхцөл, лимит батлуулах материалыг тооцоо судалгаанд үндэслэн танилцуулах.	100%
2	2023.10.27	1. Компанийн 3-р улирлын үр дүнгийн тайлан 2. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам батлах 3. ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журам батлах 4. Мэдээллийн ил тод байдал тайлагналын журам батлах 5. Сонирхлын зөрчилтэй тэмцэх журам батлах	1. Хугацаа хэтэрсэн зээлүүд дээр яаралтай арга хэмжээ авч ажиллах. 2. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хорооны гишүүд томилсон тогтоолын төсөл бэлдэж сонгогдсон гишүүд болон ТУЗ-ийн гишүүдэд танилцуулан батлуулах. 3. Нэр дэвшүүлэх хорооны журам, Цалин урамшууллын хорооны журам, Мэдээллийн ил тод тайлагналын журам, Сонирхлын зөрчилтэй тэмцэх журмыг батлах.	100%

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах ажлыг зохион байгуулж ажилдаг. Үүнд:

1. ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, гишүүдэд мэдээлэл хүргэх
2. ТУЗ-ийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах
3. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах
4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, Гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлын зохион байгуулах
5. ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулах